

# АЖЛЫН ХУУДАС 3

(бичих)

**Алхам 1.** Холбох үгсийг цэгийн оронд зөв байрлуулна уу.

Ховдог ходоод

Нүд, ам, хамар, чих, гар хоорондоо ийнхүү ярьж байна

.....

Нүд “Намайг харж байхад хамаг л гоё хоол унд, амттан шимттэн ходоод руу ороод байна” ..... ам “Харин тийм, би дөнгөж амтлаад л хоолой руу явуулдаг” ..... гомдолложээ. Хамар “Чи харин ч амтыг нь мэддэг юм байна. Би бол сайхан хоолыг дөнгөж үнэрлэхээс цаашгүй” ..... Тэгтэл гар “Би бүгдийг нь барьж үздэг ч хэзээ ч өөрөө иддэггүй. Бас гомдолтой байдаг”

.....

Тиймээс тэд “Ходоодонд саад болж хоол өгөхөө больё” ..... тохирчээ.

гэж

гэлээ

гэв

гэхэд

гэнэ

гэж

**Алхам 2.** Зөв холбоорой.



халбагаа зориуд алдаж унагав



үнэрлэхгүйг хичээв



хоол руу муухай харав



ангайхгүй жимийв



**Алхам 3.** Хоол идээгүйгээс бол ямар үр дагавар гарав?



ХОНХОЛЗОВ

